

Варшав хот, 2019 оны 11 сарын 25

Саналын дугаар. ELE-MNG/354/2019



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, УЛСЫН ИХ ХУРАЛ БОЛОН ОРОН
НУТГИЙН СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ АИХЭГ-ЫН САНАЛ**

*Энэхүү Санал Зөвлөмжийг боловсруулахад АИХЭГ-ын эксперт Марианна Скопа болон
Татьяна Хилсер-Богусейвич нар ажилласан болно.*

ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар
Ulica Miodowa 10 PL-00-251 Warsaw ph. +48 22 520 06 00 fax. +48 22 520 0605

ГАРЧИГ

I. ТАНИЛЦУУЛГА	1
II. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ЦАР ХҮРЭЭ.....	1
III. ХУРААНГУЙ.....	2
IV. ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ЗӨВЛӨМЖ.....	4
A. СОНГОХ ЭРХ	4
1. Санал өгөх эрх	4
2. Сонгогчийн бүртгэл.....	5
B. СОНГОГДОХ ЭРХ.....	6
1. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид тавих шаардлага	6
2. Нэр дэвшигчид тавигдах бусад шаардлага	6
3. Хүйсийн квот	7
C. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА.....	8
D. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА.....	8
1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх	8
2. Хоёр дахь шатны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх сурталчилгаа	9
3. Төрийн захиргааны нөөцийг ашиглах нь	9
4. Хэвлэл мэдээлэл болон цахим орчинд сурталчилгаа явуулах	10
E. СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТ	12
F. СОНГУУЛИЙН ӨДӨР.....	14
G. СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ.....	14

I. ТАНИЛЦУУЛГА

1. 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Монгол Улсаас Вена хот дахь ЕАБХАБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчийн газар нь Монгол Улсын төрийн эрх бүхий байгууллагаас хүргүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл, УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төсөл (Парламент), Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулийн төслүүд (цаашид сонгуулийн хуулийн төсөл) дээр санал гаргуулах хүсэлтийг ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газарт (цаашид АИХЭГ) дамжуулсан болно. Улмаар АИХЭГ нь сонгуулийн хуулийн төсөлд санал боловсруулж өгөхөд бэлэн байгаагаа илэрхийлсэн.

2. Санал баримт бичиг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд АИХЭГ-ын Сонгуулийн Зөвлөх Улви Ахундлу, АИХЭГ-ын экспертүүд болох Татьяна Хилсер-Богусейвич болон Марианна Скопа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж, 2019 оны 9 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотод ажилласан. Ажлын хэсэг Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ), УИХ дахь Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын дээд шүүх, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон иргэний нийгмийн төлөөллүүдтэй уулзсан юм. Энэхүү Саналд тус айлчлалын үеэр цуглуулсан мэдээллүүд тусгагдсан болно.

3. Энэхүү Саналыг сонгуулийн хууль тогтоомжийг ардчилсан сонгуулийн хүрээнд ЕАБХАБ-ын үүрэг, хариуцлага, олон улсын стандарт болон сайн туршлагад нийцүүлэн Монгол Улсын төрийн эрх бүхий байгууллагууд, улс төрийн нам болон иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих зорилготой боловсруулсан юм. Уг Саналд тусгагдсан дүгнэлт болон зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд цаашдын дэмжлэг үзүүлэхдээ АИХЭГ бэлэн байх болно.

II. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ЦАР ХҮРЭЭ

4. Энэхүү санал дүгнэлтийн цар хүрээ нь зөвхөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл, Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл (Парламент), Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулийн төслийг баримталсан болно. Түүнчлэн, тус Санал нь үүгээр хязгаарлагдаж байгаагийн хувьд Монгол Улсын сонгуультай холбоотой бусад хууль эрх зүйн өргөн цар хүрээнд хийгдээгүй болно.

5. УИХ-ын 2019 оны 9 дүгээр сарын 11-ны өдрийн гаргасан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлттэй холбоотой шийдвэрийн дагуу бүх нийтийн санал асуулга явуулснаар Сонгуулийн тухай хуулийн төсөлд дахин өөрчлөлт орох магадлалтай байна. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн сонгуультай холбоотой асуудлын хүрээнд Ерөнхийлөгчийн сонгуулийн нэр дэвшигчид тавигдах шаардлага, улс төрийн намын бүртгэл болон улс төрийн намын санхүүжилттэй холбоотой асуудлууд байх төлөвтэй байна гэсэн мэдээллийг ажлын хэсэг хүлээн авсан. Мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтөөр сонгуулийн тухай хууль тогтоомжид сонгууль болохоос нэг жилийн дотор нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглосон заалт тусгасан байна. Энэхүү Санал нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн ард нийтийн

санал асуулга явуулахаас өмнө боловсруулсан тул үүнээс үүдэн гарах нэмэлт өөрчлөлт нь энэхүү Саналд тусгагдаагүй болно.

6. Энэхүү Санал зөвлөмж нь гол асуудлыг хөндөж, цаашид дахин авч хэлэлцэх, сайжруулах шаардлагатай асуудлуудыг өгүүлсэн. Оновчтой бөгөөд тодорхой байх үүднээс бид сонгуулийн хуулийн төслүүд болон АИХЭГ-аас өмнө нь гаргаж байсан санал зөвлөмжүүдийн хүрээнд голлон анхаарч ажилласан. Санал зөвлөмжийг ЕАБХАБ-ын үүрэг, хариуцлага, бусад олон улсын стандарт болон олон улсын сайн туршлага дээр тулгуурлан гаргасан болно. Мөн энэхүү Саналд АИХЭГ-ын сонгууль ажигласан тайлангуудад дурдсан холбогдсон санал, зөвлөмжүүдээс тусгасан.

7. Энэхүү Санал нь Сонгуулийн тухай гурван хуулийн төслийн албан бус орчуулга дээр үндэслэсэн бөгөөд оновчтой бус орчуулгын үүднээс зөрүүтэй, алдаатай зүйл гарч болзошгүй.

8. Дээрх шалгааны улмаас АИХЭГ-ын зүгээс нэмэлтээр аман болон бичгэн санал зөвлөмж гаргах мөн цаашид Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид санал дүгнэлт өгөх зэрэг үйл ажиллагаанд энэхүү Санал хязгаарлахгүй гэдгийг онцолж байна.

Ш. ХУРААНГУЙ

9. Өмнөх нэгтгэсэн Сонгуулийн тухай хуульд заасан сонгуулийн хэлбэр бүрийг тус бүрчлэн зохицуулахаар сонгуулийн тухай хуулийн гурван төслийг боловсруулсан байна. Сонгуулийн тухай хуулийг буцааж тус тусад нь салгах шийдвэр нь өөр хоорондоо ялгаатай хэлбэрийн сонгуулийг илүү оновчтойгоор зохицуулах хүсэл эрмэлзэлээс үүдсэн бөгөөд тавигдах шаардлага болон хянан шийдвэрлэх ажиллагаанд тус бүрийн онцлогийг тусгахын тулд салгаж буй мэт харагдаж байна.

10. 2015 онд АИХЭГ-ын зүгээс нэгтгэсэн Сонгуулийн тухай хууль нь илүү оновчтой сонгуулийн тогтолцоог бүрдүүлэх эерэг алхам болсон хэмээн үнэлж байсан. Түүнээс хойш сонгуулийн тухай хууль нь ардчилсан сонгуулийг зохион байгуулахад нийцсэн суурь болсон хэмээн АИХЭГ үнэлсэн хэдий ч өөр хоорондоо уялдаагүй, зөрчилтэй болон эс үйлдэхүй тусгасан заалт, зохицуулалтыг дахин хянаж, засан сайжруулах хэрэгтэйг дурдсан байдаг.

11. Урьдчилсан байдлаар өгүүлэхэд, өөрчлөлт шинэчлэлтийг амжилттай хэрэгжүүлэхэд дараах гурван зүйл дээр тулгуурлах нь зүйтэй: 1) олон улсын стандарт, үүрэг хариуцлагатай нийцсэн байх бөгөөд өмнөх санал зөвлөмжүүдийг тусгасан байх; 2) холбогдох бүх талуудтай өргөн хүрээнд ил тод буюу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсаны үндсэн дээр нийтлэг санал асуулгаар хууль батлах; 3) хуулийг үнэн зөвөөр, бүрэн хэрэгжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзэл, үүрэг хариуцлагатай байх. Цаашдын хуулинд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг ил тод, нээлттэй байдлаар зөвлөлдөж, боловсруулах нь батлагдсан хуульд итгэх итгэлийг нэмэгдүүлж цаашлаад төрийн байгууллагад бүхэлд нь итгэх итгэлийг нэмэгдүүлнэ гэдгийг АИХЭГ онцолмоор байна.

12. Хэдийгээр хуулийн төсөл боловсруулах ажил дараагийн сонгуулийн хугацаа буюу 2020 оны 6 дугаар сараас нилээн өмнө эхэлсэн ч олон улсын стандарт, сайн туршлагад нийцүүлэн

сонгууль болохоос нэг жилийн өмнө сонгуулийн хуулийн үндсэн чухал хэсгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглосон заалтыг хэрэгжүүлэх боломжгүй болсон нь харамсалтай юм.¹

13. Сонгуулийн тухай хуулийн төслүүдийн хэд хэдэн зүйл, заалтуудад АИХЭГ-аас өмнө нь гаргаж байсан зөвлөмжүүдийг тусгасан байх бөгөөд олон улсын сайн туршлагад нийцүүлсэн байна. Дараах заалтууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг эерэг байна. Үүнд:

- A. Нэр дэвших зарим тодорхой хязгаарлалтуудыг хассан. Жишээ нь цэргийн алба хаасан байх;
- B. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулинд сонгогчдын нийслэл болон аймаг дотороо шилжилт хөдөлгөөн хийлгэхийг хязгаарласан заалтыг хассан;
- C. Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдэд хүйсийн квотыг нэвтрүүлэх;
- D. Сонгуулийн сурталчилгааны санхүүжилттай холбоотой заалтуудыг хянах нэг байгууллагын чиг үүргийг тодорхойлсон, сонгуулийн зардлын явц-дундын тайланг нийтлэхийг нэвтрүүлсэн, мөн мөнгөн бус хандивыг олон улсын сайн туршлагатай нийцэхээр зохицуулсан;
- E. Сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргах болон хянах үйл ажиллагаанд улс төрийн нам, нэр дэвшигч болон төрийн бус байгууллагуудыг оролцуулах эрх олгосон.

14. Гэсэн хэдий ч, Сонгуулийн тухай хуулийн төслүүд нь АИХЭГ-ын зарим зөвлөмжүүдийг тусгаагүй байх бөгөөд ихэнх нь хүний эрхийн суурь эрх, эрх чөлөөг баталгаажуулаагүй эсхүл хязгаарласан шинжтэй байна. Сонгуулийн тухай хуулийн төслүүдийг ЕАБХАБ-ын үзэл баримтлал болон олон улсын хэм хэмжээнд нийцүүлж илүү сайжруулахын тулд дараах зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:

- A. Хорих газар ял эдэлж байгаа болон чадамжгүй иргэдийн саналаа өгөх эрхийг хасах байдлыг арилгах.
- B. Нэр дэвших эрхийг хязгаарласан заалтуудыг хасах, жишээ нь хугацаа хэтэрсэн өр, татвар, гэмт хэргийн бүртгэл, бие даан нэр дэвшихэд хориглосон заалтууд болон УИХ-д суудалгүй намууд ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрх зэрэг.
- C. Доод шатны сонгуулийн хорооны бүрэлдэхүүн хэсгийг сонгох, шалгаруулах, томилох ажилд тавигдах шаардлага тодорхой байх.
- D. Албан тушаалтан төрийн захиргааны өмч болон нөөцийг хууль бусаар ашиглахыг хориглосон заалтуудыг тодорхой, ойлгомжтой байдлаар оруулж өгөх, мөн түүнчлэн үр дүнтэй хянах болон шийтгэх механизмыг бий болгох.
- E. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой заалтуудыг дахин хянаж үзэх. Жишээ нь, интернет болон сошиал медиагаар дамжуулан сонгуулийн сурталчилгаа явуулах дээр иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж болзошгүй байна.
- F. Сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх байгууллагын чиг үүргийг тодорхой заах бөгөөд маргаан шийдвэрлэх хугацааг сонгуулийн үйл ажиллагаатай уялдуулж үр дүнтэй эрхээ хамгаалах, сонгуулийн маргааныг шийдвэрлэх механизмыг боловсруулах.
- G. Сонгуулийн дүнг хэвлэн нийтлэх хуулийн зохицуулалттай нэвтрүүлэх ба дүнг сонгуулийн хэсгийн түшинд хүртэл хэсэгчилсэн нарийвчлалтай гаргах.

¹ [Сонгуулийн үйл ажиллагаан дахь сайн туршлагын хуулийн эмхтгэл](#) Европын Зөвлөлийн (Венецийн Комисс) Хуулиар Ардчиллыг хэрэгжүүлэх Европын Комисс, Удирдамж II. 2 б-г үзнэ үү.

15. Эдгээр болон зарим нэмэлт зөвлөмжүүдийг энэхүү Саналд тусгасан (Bold хэлбэрээр тодотгосон байгаа) бөгөөд ЕАБХАБ-ын үзэл баримтлал болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, стандартад нийцүүлэн Монгол Улсын сонгуулийн хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилготой. Мөн АИХЭГ-ын өмнөх сонгуулийн ажиглалтын тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг тусгасан болно.

16. АИХЭГ нь Монгол Улсын төрийн эрх бүхий байгууллагуудад цаашид туслалцаа үзүүлэх болон Сонгуулийн хуулийн төслийн эцсийн хувилбарыг дүгнэхэд бэлэн байна.

IV. ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ЗӨВЛӨМЖ

Сонгуулийн тухай хуулийн төслүүдийг боловсруулсан процесс

17. Нэгтгэсэн сонгуулийн тухай хууль 2015 онд батлагдсанаас нэг жилийн дараагаас эхлэн сонгуулийн тухай хуулийг буцааж сонгуулийн хэлбэр бүрээр нь салгаж өөр хоорондоо ялгаатай хэлбэрийн сонгуулийг илүү оновчтойгоор зохицуулах болон тавигдах шаардлага, хянан шийдвэрлэх ажиллагааг илүү оновчтой болгох санал гаргаж эхэлсэн. Тус тусад нь салгах болон бусад нэмэлт өөрчлөлтүүдийг 2016 оны 12 дугаар сард Улсын их хуралд танилцуулсан. Гэсэн хэдий ч 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулж цаг хугацаа хязгаарлагдмал байгаагийн улмаас энэхүү өөрчлөлт оруулах ажлыг хойшлуулсан.

18. Сонгуулийн шинэчлэлийг дахин эхлүүлэх ажлыг 2018 онд шийдсэн талаар манай ажлын хэсэгт мэдэгдсэн. Хуулийн төслийг боловсруулах, мөн шаардлагатай өөрчлөлтийг хийх ажлын хэсэг байгуулагдсан. Түүнээс хойш холбогдох төрийн байгууллага болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор доод тал нь гурван томоохон уулзалтуудыг зохион байгуулж, хэд хэдэн жижиг уулзалтуудыг зохион байгуулжээ. СЕХ-ны мэдээлснээр Сонгуулийн хуулийн төсөлд олон нийтийн саналыг авах үүднээс 2018 оны 10 дугаар сараас нийтэд ил болгон тавьсан байна. Иргэний нийгэм зэрэг холбогдох талуудын зүгээс нилээдгүй санал ирж түүнийг ажлын хэсэг нэгтгэсэн байна.

19. Хэдийгээр хуулийг нягтлан шинжиж үзэх энэхүү төлөвлөсөн ажил маань дараагийн сонгууль буюу төлөвлөснөөр 2020 оны 6 дугаар сар гэсэн тов гарсан байгаагаас хангалттай хугацааны өмнө эхэлсэн ч харамсалтай нь бид энэхүү ажлаа эрт гүйцэлдүүлж чадаагүй нь сонгууль явагдахаас нэг жилийн өмнө аливаа өөрчлөлтийг сонгуулийн хуулинд хийхийг хориглоно гэсэн олон улсын сайн туршлагатай нийцүүлэх аргагүй болсон юм. Талуудад Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь хууль тогтоогч нарын ажлын нэн тэргүүнд байж сонгуультай холбоотой асуудал удаах чухал зэрэглэлд багтсан хэмээн мэдэгдсэн.

A. СОНГОХ ЭРХ

1. Санал өгөх эрх

20. Санал өгөх эрхийн хувьд Сонгуулийн гурван хуулийн төсөл бүгд 2015 оны Сонгуулийн тухай хуулийн зүйл заалттай ижил байна. Шүүхээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон болон гэмт хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж буй бүх этгээдээс бусад 18

насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай бүх иргэн санал өгөх эрхтэй. Энэ мэт сонгох, сонгогдох эрхийг ял эдэлж буй болон сэтгэцийн чадамжгүй гэдгээр нь хязгаарлах нь ЕАБХАБ болон бусад олон улсын үзэл баримтлалтай үл нийцэж байна.² ***Түүнчлэн, эдгээр эрхийн хязгаарлалтуудыг хуулийн төслөөс хасах нь зүйтэй гэж зөвлөж байна; ял эдэлж буй хоригдлуудын саналаа өгөх эрхийг хязгаарлах нь тэдний үйлдсэн гэмт хэргийн ангиллаас хамаарах ёстой.***

2. Сонгогчийн бүртгэл

21. Сонгогчийн бүртгэл нь иргэдийн шууд сонгогдох эрхийн үндсэн дээр хийгдэх бөгөөд иргэний био-метрийн мэдээллийг ашиглан иргэний үндэсний бүртгэлд тулгуурлана. Сонгуулийн тухай хуулиар сонгогчид УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шилжилт хөдөлгөөн хийхийг зөвшөөрсөн. Хуулийн төсөлд дээрх боломж нь зөвхөн Ерөнхийлөгчийн сонгуулиар олгогдохоор байна; АИХЭГ-аас гаргасан өмнөх зөвлөмжүүдийн дагуу аймаг дотроо шилжилт хөдөлгөөн хийхийг хориглохгүй байх ба хуулийн шинэ заалтаар сонгуулийн санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө шилжилт хөдөлгөөн хийхээр хугацааг сунгаж өгчээ. Энэхүү уртасгасан хугацаа нь ямар зорилго, үйлчлэлтэй байх нь тодорхойгүй бөгөөд иргэний санал өгөх эрхэнд халдах магадлалтай байна. Сонгогч шилжилт хөдөлгөөн хийх хүсэлтээ шилжин очих сонгуулийн хэсэгтээ хүргэж өгөх ёстой байхаар зааж өгсөн нь шилжилт хөдөлгөөн хийх ажиллагааг түвэгтэй болгож байна гэж үзэж байна.

22. УИХ-ын сонгуулийн үеэр шилжилт хөдөлгөөнийг зөвхөн сонгуулийн байгууллагын ажилтнууд, мэдээлэл технологийн багийн гишүүд, нэр дэвшигчийн менежер, шадар туслах болон ухуулагч нар хүсэлт гаргаж, нэр дэвшигч эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолт дээр үндэслэж хийх³ бөгөөд үүнд ямар ч хугацаа зааж өгөөгүй байна. Гэсэн хэдий ч зөөврийн битүүмжилсэн саналын хайрцааг санал өгөх эрхийг сонгуулийн ухуулагч, ажилтнаас бусдад хэвээр үлдээсэн байна.⁴ ***Санал авах өдөр сонгуулийн санал авах байрны ажилтан, цагдаа зэрэг албан үүргээ гүйцэтгэж яваа хүмүүсийн саналаа өгөх талаарх заалтууд илүү тодорхой байх нь зүйтэй.***

23. Сонгуулийн хуулийн төсөлд тусгаснаар улс төрийн намуудын төлөөлөл, эвсэл, төрийн бус байгууллага, нэр дэвшигчид сонгогчийн нэрсийн жагсаалтыг үйлдэх, давхардсан нэрсийг хасах, зөөвөрлөх үйл ажиллагааг ажиглаж болно хэмээн заажээ.⁵ Гэвч эдгээр үйл

² “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 25-р зүйлд өгсөн [НҮБХЭЖ-ын 25-р Ерөнхий тайлбарын 14 дэх](#) хэсэгт “хэрэв гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл нь санал өгөх эрхийг нь түдгэлзүүлэх үндэс болсон бол ийнхүү түдгэлзүүлсэн хугацаа нь үйлдсэн гэмт хэрэг болон оногдуулсан ял шийтгэлтэй тохирч байх ёстой” гэжээ. ЕАБХАБ-ын [1990 оны Копенгагений Баримт бичгийн 24 дэх](#) хэсэгт “ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан аливаа заалт нь холбогдох хуулийн аль нэг зорилттой уялдаж байхаас гадна тухайн хуулийнхаа зорилготой хатуу нийцэж байх ёстой” гэж заажээ. Мөн [2006 оны НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид](#) (ХБХЭЖ) “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн үйл хэргийг хэрэгжүүлэхэд ялгаварлан гадуурхалгүйгээр бусадтай адил тэгш нөхцөлд үр ашигтай, бүрэн оролцох орчин нөхцөлийг идэвхтэйгээр сурталчилж, нийтийн үйл хэрэгт тэдний оролцоог урамшуулах гэж зааж өгсөн ба Заалт 12-т “Төрийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хуулийн бүрэн чадамжтэй гэдгийг хүлээн зөвшөөрч тэд амьдралын бүхий л зүйлийг бусдын адил хүртэх эрхтэй”.

³ Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн төсөлд ижил заалт тусгасан.

⁴ Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 59.2 заалт болон УИХ-ын сонгуулийн хуулийн 70.2 заалт.

⁵ СТХ-д сонгогчдын нэрсийн жагсаалын цахим хувилбарыг улс төрийн нам болон эвслийн төлөөлөгч нарт хүсэл гаргасныг нь үндэслэж өгөх.

ажиллагааг ажиглахыг хүссэн хүмүүс Тагнуулын төв байгууллагад бүртгүүлсэн байх ёстой бөгөөд тагнуулын төв байгууллага нь сонгогчийн нэрсийн жагсаалтыг үйлдэх, давхардсан нэрсийг хасах, зөвөрлөх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг хуулийн төсөлд тусгагдсан байна. Үүнээс гадна, нэрсийн жагсаалтыг үйлдэх ажиллагааг хянах эрх бүхий хүмүүст сонгогчдын нэрсийн жагсаалтад “нэвтрэх эрх”-ийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал дээр үндэслэн Тагнуулын төв байгууллага гаргана. *Сонгогчийн нэрсийн жагсаалтыг үйлдэх ажиллагаанд Тагнуулын төв байгууллага яагаад оролцох шаардлагатай нь тодорхойгүй байх бөгөөд “хяналт” нь ямар ач холбогдолтой нь тодорхойгүй байна.*

В. СОНГОГДОХ ЭРХ

1. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид тавих шаардлага

24. АИХЭГ-ын өмнөх санал зөвлөмжүүдийг үл харгалзан, Ерөнхийлөгчийн хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг тусган одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа УИХ-д суудалгүй нам нэр дэвшүүлэх болон бие даан нэр дэвших боломж олгоогүй хуулийн зүйл заалт хэвээр үлдээсэн байна. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрхийг зөвхөн УИХ-д суудалтай улс төрийн намуудад олгосон нь ЕАБХАБ-ын үзэл баримтлал болон бусад олон улсын дагаж мөрдөх үүрэг, хариуцлагын⁶ эсрэг байх бөгөөд энэ нь сонгогчдын сонголтыг хязгаарлаж байна. АИХЭГ-ын сонгуулийн ажиглалтын хүрээнд байнга давтагддаг зөвлөмж нь тус хуулийг ЕАБХАБ-ын үзэл баримтлалд нийцүүлэхийн тулд Ерөнхийлөгчийн сонгуульд бие дааж нэр дэвшихийг зөвшөөрсөн холбогдох заалтуудыг тусгах явдал байсан.

25. Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарласан заалтууд Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн төсөлд хэвээр орсон байна. Ерөнхийлөгчид нэр дэвшигч 45 нас хүрсэн байх, Монгол Улсын уугуул иргэн байх, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан байх гэсэн шаардлагыг хангана. Манай ажлын хэсэгт мэдээлснээр бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөөр насны хувьд тавигдах шаардлагыг 50 нас болгож өсгөх, мөн Ерөнхийлөгчөөр ажиллах хугацааг нэг удаа 6 жил болгож байгаа хэмээн мэдэгдсэн. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн төсөлд зөвхөн УИХ-д суудалтай улс төрийн намууд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх давуу байдлыг хэвээр үлдээж, нэр дэвшигчид тавигдах шаардлагад өөр нэмэлт, өөрчлөлт оруулаагүй байна. *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлийн холбогдох заалтуудыг ЕАБХАБ-ын үзэл баримтлалд нийцүүлэх үүднээс одоогийн хэрэгжиж буй сонгогдох эрхийн хязгаарлалтыг шийдвэрлэх боломжоо ашиглахад анхаарах нь зүйтэй.*

2. Нэр дэвшигчид тавигдах бусад шаардлага

⁶ ЕАБХАБ-ын [1990 оны Копенгагений Баримт бичгийн](#) 7.5 дахь хэсэгт “Гишүүн орнууд нь иргэдийн улс төрийн болон нийтийн албан тушаал хаших эрхийг ялгаварлан гадуурхалгүйгээр хүндэтгэнэ” гэж заажээ. НҮБХЭК-ын Ерөнхий тайлбарын 25-с Нийтлэл 25-д 17-р хэсэгт “хувь хүний сонгуульд нэрээ дэвшүүлэх эрх нь тэднийг улстөрийн намын гишүүн байх эсхүл тодорхой намын гишүүн байх зэргээр шаардаж эрхийг нь хязгаарлах ёсгүй.” Хэмээн баталгаажуулж өгчээ.

26. УИХ-ын сонгуульд нэр дэвшигч нь 25 нас хүрсэн байх ёстой. Орон нутгийн сонгуульд нэр дэвшигч мөн адил 25 нас хүрсэн байх ёстой бөгөөд нэр дэвшиж байгаа засаг захиргааны нэгжид сонгуулийн өдрөөс 180-аас доошгүй хоног оршин суусан байх ёстой.⁷ Бүх хэлбэрийн сонгуульд нэр дэвшигч өр төлбөргүй, татварын өргүй мөн гэмт хэргийн ял шийтгэл хүлээгээгүй байх шаардлагатай байна. АИХЭГ-ын сонгуулийн ажиглалтын хороо сонгуулийн тухай гурван хуулийн төсөлд гурвууланд нь тусгагдсан эдгээр шаардлагуудыг хэтэрхий хязгаарласан байна гэж дүгнэсэн.

27. Эерэг өөрчлөлтөөс дурьдвал, сонгуулийн тухай хуулийн төсөлд цэргийн алба хаах ёстой гэсэн шаардлага тусгагдаагүй байна. Түүнчлэн, Сонгуулийн тухай хуульд зааснаар улс төрийн намууд УИХ-ын сонгуульд нэр дэвшигчээ сонгохдоо эх орныхоо сайн сайхны төлөө, ард түмнийхээ төлөө ажиллаж чадахуйц боловсрол, туршлага, ур чадвар, хүсэл эрмэлзэлтэй байх ба үнэнч шударга байх, хууль дээдлэх, ёс зүйн хэм хэмжээ зэргээс хамаарч хувь хүнийг Улсын их хурлын гишүүн байх чадвартай эсэхийг дүгнэн гаргах үүрэг бүхий заалтыг хассан байна. АИХЭГ-ын өмнөх зөвлөмжийн дагуу Сонгуулийн тухай хуулинд төрийн албан хаагч нэр дэвшихэд сонгууль болохоос нилээн хэдэн сарын өмнө ажлаа хүлээлгэн өгсөн байна гэсэн заалтыг өөрчилж нэр дэвших ажиллагаа эхлэхэд ажлаа хүлээлгэн өгнө хэмээн өөрчилсөн байна.⁸ ***Нэр дэвших эрхийг хязгаарласан зарим заалтуудыг хассан ч тухайн нутаг дэвсгэрт оршин суусан байх зэрэг бусад хязгаарлалтуудыг эргэж харах нь зүйтэй.***

3. Хүйсийн квот

28. Улс төрийн нам болон эвслээс УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдэд тавьсан 20 хувийн квотыг хэвээр нь хадгалагдсан байна. Үүнээс гадна, орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдэд тавьсан 10 хувийн квотыг шинээр нэмэгдсэн байна. Хэдийгээр эдгээр эмэгтэйчүүдийн нэр дэвших байдлыг нэмэгдүүлэх зорилготой заалтуудыг сайнаар хүлээж авч байгаа ч квотын хэмжээ бага байхаас гадна мажоритар тогтолцоонд эмэгтэйчүүд илүү сонгогдоно гэсэн үг биш юм. 2016 оны УИХ-ын сонгуульд бүх улс төрийн намууд квотын хэмжээг хангасан ч АИХЭГ-ын сонгуулийн ажиглалтын хорооны ажигласнаар сонгуулийн тойргийн гуравны нэгд эмэгтэй нэр дэвшигчид байгаагүй. 2016 онд сонгогдсон эмэгтэй гишүүд зөвхөн 17 хувийг бүрдүүлж байна.

29. Түүнчлэн, хэрэв квотыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хуулийн ямар ч үр дагавар байхгүй бөгөөд ямар ч хуулийн шийтгэл заагаагүй байна. ***Эмэгтэйчүүдийн нэр дэвших байдлыг идэвхжүүлэх заалтуудыг илүү тодорхой, хүчтэй болгох шаардлагатай бөгөөд үүнд хуулийн заалтыг биелүүлэхгүй тохиолдлоос зайлсхийх хуулийн хариуцлага тусгах нь зүйтэй. Квотын үр дүн нь мажоритар тогтолцоонд бага байдгийг бодолцон санхүүгийн урамшуулал зэргийг нэвтрүүлэх нь зүйтэй.***

⁷ “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын [25-р зүйлд өгсөн НҮБХЭК-ын 25р Ерөнхий тайлбарын](#) 15 дахь хэсэгт “Сонгогдох эрх эдлэх боломжгүй хүмүүсээс бусад хүмүүс нь боловсрол, оршин суугаа газар, гарал үүсэл, эсвэл улс төрийн харьяаллын шалтгаан гэх мэт үндэслэлээр ялгаварлан гадуурхагдах ёсгүй” гэж заасан байдаг”. ЕАБХАБ-ын [1990 оны Копенгагений 24-р хэсэгт](#) эрх болон эрх чөлөөг хязгаарлах байдал шууд хуулийн зорилготой нийцэх ёстой хэмээн зааж өгчээ.

⁸ СТХ-д зааснаар, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч сонгуулийн өмнөх жилийн 1 сарын 1-ээс төрийн албан хаагчийн ажлаа хүлээлгэн өгсөн байх харин УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвшигч сонгуулийн өмнөх жилийн 1 сарын 31-ээс өмнө ажлаа хүлээлгэн өгсөн байх ёстой.

С. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

30. Сонгуулийн байгууллага нь улсын нутаг дэвсгэрийн зохион байгуулалттай нийцэх бүтэцтэй. Сонгуулийг 4-шатлал бүхий сонгуулийн байгууллага удирдан зохион явуулдаг. Тэдгээр нь байнгын ажиллагаатай Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ),⁹ Аймаг нийслэлийн сонгуулийн хороо (АНСХ), Сум дүүргийн сонгуулийн хороо (СДСХ), мөн санал авах, санал тоолох зэрэг ажлыг гүйцэтгэх Сонгуулийн хэсгийн хороо (СХХ). АНСХ, СДСХ болон СХХ-ууд нь түр ажиллах байгууллагууд болно. Сонгуулийн тухай хуульд дээрх сонгуулийн хороодод ажиллах хүмүүсийн сонгон шалгаруулалтын талаар баримтлах шаардлага тусгагдаагүй бөгөөд зөвхөн төрийн албан хаагч байх, сонгуулийн байгууллагаас удирдан зохион явуулдаг сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх ёстой гэсэн шаардлага туссан байх ба ажилд томилох ямар ч дэлгэрэнгүй болон нэгдсэн механизм байхгүй байна. Сонгуулийн тухай хуулийн төсөл нь төстэй зүйл заалттай байх ба өөр ямар ч нэмэлт шаардлага тусгаагүй байна.

31. АИХЭГ-ын сонгууль ажиглах хороо нь АНСХ болон СДСХ-ын үйл ажиллагаа болон шийдвэрт улс төрийн нөлөөлөл байж болзошгүй талаар хэд хэдэн мэдээлэл хүлээн авч байсан. Эдгээр мэдээллүүд ихэвчлэн сонгуулийн хороодын бүрэлдэхүүнтэй холбоотой үүссэн байсан ба ихэнх тохиолдолд орон нутгийн түвшинд эрх мэдлийн нөлөөг харах боломжтой. *Нөлөөллийн талаарх ташаа ойлголтыг бууруулж, сонгуулийн байгууллага дахь иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд сонгуулийн доод шатны хороодын бүрэлдэхүүнийг томилохдоо дэлгэрэнгүй бөгөөд ил тод шаардлагуудыг бий болгох нь зүйтэй.*

Д. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх

32. Сонгуулийн тухай хуулийн төслийг Сонгуулийн тухай хуультай харьцуулахад сонгуулийн сурталчилгааны хувьд хэдхэн өөрчлөлт орсон байна. Улс төрийн нам болон нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хөгжлийн болон эдийн засгийн бодлоготой нийцэж байгаа эсэхийг Үндэсний аудитын газар шалгах зэрэг хязгаарлалт бүхий заалтыг хэвээр хадгалжээ. Сонгуулийн сурталчилгааны зарим зүйлс, жишээ нь сонгуулийн сурталчилгаанд ашиглах унаа тээврийн тоо хэмжээ, сонгуулийн төв штабад ажиллах хүний тоо болон хөрөнгө, нөөцийн дээд хэмжээг заасан байна. Сурталчилгааны хугацааг сунгаж сонгуулийн тухай хуулийн хүрээнд Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа 19 хоногийн хугацаатай байгаа бол хуулийн төсөлд доод тал нь 30 хоног болгож нэмсэн байна;¹⁰ харин УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн сурталчилгааны хугацаа Сонгуулийн тухай хуульд 17 өдөр байхаар заасан бол хуулийн төсөлд 21-ээс доошгүй өдөр байхаар заасан байна.

⁹ СЕХ-ны үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх мэдэл нь Сонгуулийн Төв байгууллагын хуулиар зохицуулагдана.

¹⁰ СТХ-д сонгуулийн сурталчилгаа тогтсон цаг хугацаатай байсан бол сонгуулийн хуулийн төсөлд сонгуулийн сурталчилгааны өдрийн эхлэлийг нэр дэвшигчид нэр дэвшигчдийн үнэмлэхээ сонгуулийн хорооноос авсан цагаас эхлэхээр зааж өгсөн бөгөөд Ерөнхийлөгчийн сонгуульд 31-ээс доошгүй өдөр, УИХ болон орон нутгийн сонгуульд 22-оос доошгүй өдөр байхаар хуульчилж өгсөн.

33. Хуулийн төсөлд ‘бусдын нэр төрд халдах, гүтгэн гүжирдэх, бусдын нэрийг гутаан доромжлох, эсхүл худал хуурмаг мэдээ мэдээлэл тараах’ зэргийг хориглосон заалтууд хэвээр хадгалжээ.¹¹ Мөн ‘нэр дэвшигчийг гүтгэн харлуулах, нэр төрийг нь гутаах’-ыг хориглосон байна. Эдгээр хязгаарлалтууд нь улс төрийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх олон улсын үүрэг, амлалттай нийцэхэд хүндрэлтэй байна.¹² *Үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалж дэмжихийн тулд, сонгуулийн сурталчилгааны хэсгийн заалтуудыг аль болох бага хязгаарлалттай байх талаар дахин авч үзэх нь зүйтэй.*

2. Хоёр дахь шатны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх сурталчилгаа

34. Сонгуулийн тухай хуулинд хэрэв адил тооны санал авсан тохиолдолд, эсхүл ирц 50-иас доош хувьтай байж нэмэлт болон дахин санал хураалтын өмнө эсхүл сонгуулийг хүчингүйд тооцсон тохиолдолд сонгуулийн сурталчилгаа явуулахыг маш тодорхой хориглосон байх боловч Ерөнхийлөгчийн сонгуулийн анхан буюу хоёр дахь шатны сонгуулийн сурталчилгааны талаар чимээгүй байна. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Сонгуулийн тухай хууль дахь заалтуудыг хязгаарлагдмал байдлаар тайлбарласан нь хоёр дахь шатны сонгуулийн үеэр сонгуулийн сурталчилгаа явуулах нь хориотой гэж холбогдох талууд болон СЕХ ойлгуулсан. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл нь энэхүү хуулийн цоорхойг нөхөж чадаагүй байна. *Хоёр шатны хоорондын сонгуулийн сурталчилгааг хүлээн зөвшөөрч хуулиар зохицуулж өгөх нь зүйтэй.*

3. Төрийн захиргааны нөөцийг ашиглах нь

35. Улс төрийн албан тушаалтангууд сонгуулийн сурталчилгаанд оролцож болно. Гэсэн хэдий ч Сонгуулийн тухай хуулинд ч, сонгуулийн тухай хуулийн төсөлд ч, тэдний төрийн захиргааны ажил болон сонгуулийн сурталчилгааны ажлын талаар тодорхой зааг ялгаа гаргах заалтууд байхгүй байна. АИХЭГ-ын өмнөх тайлангуудад холбогдох хүмүүс албан тушаалаа ашиглах нь тэдний төрийн захиргааны ажил болон сонгуулийн сурталчилгааны ажлын хоорондын зааг ялгааг бүрхэгдүүлж байна гэдгийг онцолсон. Сонгуулийн тухай хуулийн төслүүдэд зааснаар улс төрийн албан тушаалтан нь хийсэн ажлын тайлангаа сонгуулийн жилийн 2 дугаар сарын 1-ээс хойш нийтлэхийг хориглосон нь зөв чиглэл рүү явж байгаа хэдий ч,¹³ Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөлд тусгагдсан

¹¹ СТХ-д энэхүү заалтыг зөрчснөөр торгууль төлж улмаар УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвших бүртгэлээс хасах заалттай. Орон нутгийн сонгуулийн хуулийн төсөлд орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчдийг бүртгэлээс хасах шийтгэл туссан гэвч УИХ-ын сонгуулийн хуулийн төслөөр энэхүү заалтыг зөрчснөөр зөвхөн торгуулахаар тусгасан байна.

¹² “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын [НҮБХЭК Ерөнхий тайлбар 25-с Нийтлэл 25](#) -ын 25 дахь хэсэгт “иргэд, нэр дэвшигчид болон сонгууль ажилтнуудын хоорондын мэдээллийн болон санааны чөлөөт харилцаа нь маш чухал.” хэмээжээ. Мөн [НҮБХЭК Ерөнхий тайлбар 34-с Нийтлэл 19](#) -ын 38 дахь хэсэгт “төрийн албан хаагчийг доромжилсонд тооцогдох үзэл бодлын баримт төдий зүйл нь шийтгэл оногдуулах хангалттай шалтгаан болохгүй...Түүнчлэн, төрийн дээд байгууллага болох хуулийн байгууллагын хууль тогтоогчоос авахуулаад бүх төрийн албан хаагчид шүүмжлэл болон улс төрийн эсэргүүцэлд өртөх нь хууль ёсны юм.”

¹³ СТХ-нд тусгаснаар ийм төрлийн тайланг сонгуулийн сурталчилгааны үеэр ч хэвлэн нийтэлж болно хэмээн зааж өгсөн; түүнчлэн энэ төрлийн тайланг сонгуулийн сурталчилгааны материал хэмээн тооцохгүй гэжээ.

холбогдох заалтыг дахин хэлэлцэх нь илүү ашиг тустай.¹⁴ Улс төрийн нам болон төр хоорондын ялгаатай байдлыг зохицуулсан хуулийн заалт болон үр дүнтэй санц байхгүй байгаа нь ЕАБХАБ-ын болон олон улсын үүрэг хариуцлагатай нийцэхгүй байна.¹⁵ ***Бүх нэр дэвшигч нарт тэгш өрсөлдөх боломж бүрдүүлэх үүднээс төрийн захиргааны нөөц бололцоог хууль бусаар ашиглахгүй байхыг заасан тодорхой заалт оруулж, үр дүнтэй шийтгэл оноох сайн механизм нэвтрүүлэх нь зүйтэй.***

4. Хэвлэл мэдээлэл болон цахим орчинд сурталчилгаа явуулах

36. АИХЭГ-ын сонгуулийн ажиглалтын хорооны ажиглалтаар сонгуулийн сурталчилгааны үеийн нэг нэр дэвшигч, намд оногдож буй хэвлэл мэдээлийн цаг нь хязгаарлагдмал бөгөөд тогтмол бус хэмээн дүгнэсэн байдаг. Сонгуулийн тухай хуулийн төслөөр энэ хүрээнд маш бага өөрчлөлт хийсэн байна. Харилцаа холбооны зохицуулах хороо нь (ХХЗХ) олон нийтийн телевиз, радиогоор оногдох үнэгүй цагийг хувиарлах болон цаг оноох ажлыг хариуцаж СЕХ-оос энэ чиг үүргийг шилжүүлсэн байна. Түүнчлэн, олон нийтийн телевиз, радио нь саналаа хянуулахаар ХХЗХ-д илгээж улмаар сонгуулийн сурталчилгаа эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө зөвшөөрлөө авахаар заасан байна.¹⁶

37. Улс төрийн нам болон нэр дэвшигчдэд оногдох мэдээний нэвтрүүлгийн цагийг 5 минутаас 10 минут байхаар сунгаж өгсөн ба мэтгэлцээн явуулахад Ерөнхийлөгчийн сонгуулийн бүх нэр дэвшигчид оролцох, УИХ болон орон нутгийн сонгуулийн мэтгэлцээнд дор хаяж 4 нэр дэвшигч оролцох гэх мэт хэтэрхий нарийвчлал бүхий шаардлагыг хэвээр нь хадгалсан байна. 2016 оны УИХ-ын сонгуулиар АИХЭГ-ын Сонгуулийн ажиглах хорооны ажигласнаар 4-өөс доош нэр дэвшигчтэй тойрогт орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага мэтгэлцээн зохион байгуулах боломжгүйд хүргэсэн болно гэсэн байна. Эдгээр заалтууд нь редакцын эрх чөлөөг хязгаарлаж, мэдээллийн олон ургальч үзэл болон чөлөөт урсгалыг алдагдуулж болзошгүй юм.¹⁷ ***Сонгуулийн сурталчилгааны хувьд шударга болон тэнцвэртэй хувиарлалтыг бий болгох үүднээс эдгээр заалтуудыг дахин харж улмаар хэвлэл мэдээллийн бие даасан байдал болон редакцийн эрх чөлөөг хүндэтгэх нь зүйтэй.***

¹⁴ 33.9-р зүйлд “УИХ-ын гишүүн сонгуульд нэр дэвшиж байгаа бол тэдний үйл ажиллагааны тайлан сонгуулийн жилийн 2 дугаар сарын 1-ээс өмнө тараагдах ёстой.” хэмээжээ. Харин Ерөнхийлөгч сонгуульд нэр дэвшиж байгаа тохиолдлыг авч хэлэлцээгүй байна.

¹⁵ [1990 Копенгагений Баримт бичиг 5.4](#) заалт: “Төр болон улс төрийн намын хоорондын тодорхой зааг ялгаа”. Түүнчлэн [2016 оны ЕАБХАБ / АИХЭГ-ын болон Венецийн комиссын Улс төрийн намуудын зохицуулалтын удирдамж зааж буйгаар](#) “хууль эрхзүйн орчин төрийн албан хаагчид албан тушаалаа урвуулан ашиглахгүй байх, сонгуулийн сурталчилгааны шугамаар, хандивын арга хэмжээ, намын нэр дэвшигчдэд тусламж үзүүлэхгүй байх. Мөн сонгогчид талуудыг хариуцлагатай байлгахын тулд улс төрийн намуудад олгож буй санхүүгийн дэмжлэгийн талаар холбогдох мэдээлэл авсан байх эрхтэй”. Тодруулбал, ямар санхүүжилт ашиглаж байгааг тодорхой тайлагдах (төрийн эсхүл орон нутгийн төсөв) байгууллагын нөөц (ажилтан, унаа тэрэг, дэд бүтэц, утас, компьютер зэрэг). Энэ нь нэр дэвшигчид ажлын бус цагаар төрийн нөөц хөрөнгийг ашиглахгүйгээр сонгуульд нэр дэвшихийг хориглоогүй”.

¹⁶ СТХ-д олон нийтийн хэвлэл мэдээллийнхний саналыг аваад сонгуулийн сурталчилгаа эхлэхээс 5-с доошгүй хоногийн өмнө батална гэдгийг урьдчилан хараагүй.

¹⁷ [НҮБХЭК Ерөнхий тайлбар 25-с Нийтлэл 25](#) -ын 25 дэх хэсэгт “25 дугаар заалтын эрхийг бүрэн эдлэхийн тулд иргэд, нэр дэвшигчид, сонгогдсон төлөөлөгчид олон нийтийн болон улс төрийн асуудлаарх мэдээллийн болон санааны чөлөөт харилцаа нэн чухал. Ингэснээр чөлөөт хэвлэл мэдээлэл болон бусад хэвлэл мэдээлэл цэнцүргүйгээр, хавчлагагүйгээр олон нийтийн асуудал дээр дуугарч олон нийтийг мэдээллээр хангах боломжтой.”

38. Сонгуулийн тухай хуулийн төсөлд хуулийн зарим зүйл заалтуудыг зөрчсөн байдлыг хянах эрхийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт олгосон хэвээр боловч зарим зүйл заалтуудыг хянах эрхийг ХХЗХ-д олгосон хэвээр байна. Энэ асуудлын хүрээнд АИХЭГ-ын зүгээс байнга санал болгож буй зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй орхигдуулсан хэвээр байна. *Сонгуулийн сурталчилгааны мэдээний нэвтрүүлгийн цаг болон хэвлэл мэдээлэлтэй холбоотой бүхий л өргөдөл, гомдлыг хариуцан хянадаг бие даасан нэг байгууллага байх нь зүйтэй.*

39. Хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг зөрчсөн мөн төлбөртэй улс төрийн нэвтрүүлгийг хянаагүйн төлөө хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хугацааг Сонгуулийн тухай хуульд 6 сар байсныг Сонгуулийн тухай хуулийн төсөлд 3 сар болгож бууруулсан байна. Хуулийн төслөөр мөн санал асуулга явуулахыг ерөнхийд нь хориглосон мэт харагдаж байна.¹⁸ Сонгуулийн тухай хуулинд заасан санал авах өдрөөс долоо хоногийн хугацаанд санал асуулгын төрлийн мэдээллийг тараах гэсэн заалт хасагдсан нь санал асуулгын талаар ерөнхийд нь хязгаарласан байна.¹⁹ *Санал асуулга нийтлэхийг хориглосон нь үзэл бодлоо илэрхийлэх зарчимтай үл нийцэж байгаа тул асуулт дагуулж байна. Түүнчлэн дахин авч хэлэлцэх нь зүйтэй.*

40. Сонгуулийн тухай хуулийн төсөл нь цахим орчин дахь сурталчилгааны талаар Сонгуулийн тухай хуульд зааж өгснөөс илүү дэлгэрэнгүй зохицуулж өгсөн байна. Эдгээр зохицуулалтууд нь хэд хэдэн асуултуудыг дагуулж байна. Хуулийн төслийн хүрээнд нэр дэвшигчид, улс төрийн намууд, болон эвслүүд тус бүр сонгуулийн сурталчилгааны цахим хуудас ажиллуулж болох бөгөөд, мөн бусад цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр дамжуулж сонгуулийн сурталчилгааа хийж болохоор байна. Нэр дэвшигчид, улс төрийн намууд болон эвслүүдийн цахим хуудас болон нийгмийн сүлжээний дансаа ХХЗХ-нд бүртгүүлэх (УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд) мөн сонгуулийн холбогдох хороодод (орон нутгийн сонгуулийн хувьд) бүртгүүлэх үүрэгтэй. Бүртгэгдээгүй цахим хуудас ашиглахыг мөн “бусдын нэр” болон хаягийг ашиглахыг хориглосон байна. “Бусдын нэр” гэдэг нь хуурамч нэрийг хэлж байгаа эсхүл хуурамч хүнийг хэлж байгаа эсэх нь тодорхойгүй байна. “Бусад цахим хуудас” гэдэг үгний утга ч мөн адил тодорхой бус байна; холбогдох заалтуудад дурьдахдаа хэрэв эдгээр цахим хуудаснуудад сонгуулийн сурталчилгаа явуулж туг, тэмдэг, нэр дэвшигчийн нэр, цахим хуудас зэргийг сурталчилах юм бол үүнийг гуравдагч талын талбарт төлбөртэйгээр хийсэн улс төрийн сурталчилгаа хэмээн ойлгогдохоор байна. Зөвхөн албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ бүхий дансаа бүртгүүлэх шаардлагатай нь “бусад цахим хуудас” зэрэг бусад бүх цахим хуудасуудад сонгуулийн өдөр хүртэлх хандах эрхийг Монгол Улсын хэмжээнд түр түдгэлзүүлэх болзошгүй. Хэрэв ХХЗХ-нд бүртгүүлэх ёстой гэсэн заалтыг зөрчсөн байгууллага нь “олдохгүй” бол холбогдох торгуулийн шийтгэл оногдох боломжгүй. Ингэж

¹⁸ Сонгуулийн сурталчилгааны хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан Европын Сайд нарын Зөвлөлийн Комиссын [CM/Rec\(2007\)15 Зөвлөмжүүд](#) 8 дэх хэсэгт "Санал авах өдөр эсхүл санал авах өдрөөс хэдэн өдрийн өмнө (санал авах зорилгоор) санал асуулгын талаар хэвлэн нийтлэх/түгээх ...-д тавих аливаа хязгаарлалт нь ЕХЭЖ-ын 10-р заалтын дагуу хийгдэх ёстой гэж Европын Хүний Эрхийн Шүүхийн тодорхойлжээ. [Сонгуулийн санал асуулгын хэвлэн нийтлэхийг хязгаарласан хуулийн харьцуулсан судалгааны](#), 19-р Заалт “24 цагаас илүү хугацаагаар хоргилох нь ховор тохиолдол бөгөөд онцгой нөхцөл байдлаас хэтэрсэн зүйл. Түүнчлэн үүнийг зөвөөр шийдвэрлэх боломжтой байх ёстой.”

¹⁹ СТХ-ийн 70.2-д зааснаар: “Аливаа этгээд санал авах өдөр хүртэлх долоо хоногийн хугацаанд нам, нэр дэвшигчдийн талаар санал асуулга явуулах, энэ төрлийн мэдээллийг бүх төрлийн хэвлэл мэдээлэл ашиглан нийлэн тараахыг хориглоно” Энэ заалт нь 70.1 болон 82.16-д заасан ерөнхий хориг бүхий заалттай зөрчилдөж байна хэмээн харагдаж байна.

заасан заалт нь нэр дэвшигчийн үйлдсэн зөрчлийн улмаас гуравдагч талын цахим хуудсыг торгож шийтгэх мэт харагдаж байна. Мөн энэ нь улс төрийн нам болон нэр дэвшигчидтэй ямар ч холбоогүй нийгмийн сүлжээ ашиглагч хувь хүмүүст хариуцлага тооцох боломжийг бүрдүүлэхээр харагдаж байгаа бөгөөд харин тэд зүгээр л нийгмийн сүлжээнийхээ нэрээр дамжуулж нэр дэвшигчдийн талаар үзэл бодлоо илэрхийлж байж болно. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэт бөгөөд харьцангуй хязгаарлаж байгаа явдал юм. ***Нэр дэвшигчдийн зөрчлийн улмаас гуравдагч талуудыг болон хувь хүмүүсийг хариуцлагад татах байдлыг арилгах үүднээс эдгээр заалтуудыг эргэж харах нь зүйтэй.***

41. Албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээн дэх санал сэтгэгдэл (коммент) зэргийг хаах шаардлагатай заалтууд байгаа бөгөөд энэхүү заалтыг зөрчвөл торгуултай байна. Иймэрхүү хязгаарлалт нь улс төрийн хэт буруу мэтгэлцээнд саад учруулж улмаар мэдээллийн чөлөөт урсгалыг зогсоох ба үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахад хүлээсэн үүргээ зөрчихөд хүргэнэ.²⁰ ***Холбогдох заалтуудыг дахин авч хэлэлцэж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх олон улсын үүрэг хариуцлагатай нийцүүлэх шаардлагатай.***

Е. СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТ

42. Сонгуулийн сурталчилгааг хандив болон улс төрийн нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлдэг. Бүх гүйлгээ банкинд нээсэн сонгуулийн зардлын дансаар хийгдэнэ. Сонгуулийн зардлын данснаас өөр дансанд болон хандивын бус аргаар сонгуулийн санхүүжилт төвлөрүүлсэн тохиолдолд Сонгуулийн тухай хуулийн төсөл нь Сонгуулийн тухай хуульд заасан дүнгээс өндөр торгууль тогтоож өгсөн байна.²¹ Сонгуулийн сурталчилгааны зардлын данс нь зөвхөн Үндэсний аудитын газарт (ҮАГ) бүртгүүлэх; Сонгуулийн тухай хуульд зардлын дансыг СЕХ болон Татварын ерөнхий газарт бүртгүүлэх шаардлага байхгүй байна. Ерөнхийд нь авч үзвэл Сонгуулийн хуулийн төслийн заалтууд нь ҮАГ сонгуулийн сурталчилгааны зардлыг хянах, хуульд нийцүүлэх зэргийг хариуцсан цор ганц байгууллага гэдгийг зааж өгсөн байна.²² Тодруулбал, сонгуулийн сурталчилгааны зардлын дансны хажуугаар, намын болон нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан, сонгуулийн сурталчилгааны зардлын дансны гүйлгээний талаарх банкны мэдээлэл зэрэг нь шууд ҮАГ-т хүргэгдэж сонгуулийн санхүүжилттэй холбоотой СЕХ-ны чиг үүргийг хассан мэт харагдаж байна. Үүнийг эерэг хөгжил хэмээн дүгнэж байгаа бөгөөд талуудын үүрэг хариуцлагын давхцыг арилгаж улмаар хяналтыг сайжруулна.

²⁰ “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын [НҮБХЭК Ерөнхий тайлбар 34-с Нийтлэл 19](#) “19-р заалтын 2 дахь хэсэгт үзэл бодлоо илэрхийлэх эрхийг Төр баталгаажуулна хэмээн зааж өгсөн. Үүнд хайх, хүлээж авах, дамжуулах орох бөгөөд мөн улс төрийн яриа хийх, өөрийн болон олон нийтийн асуудлаар сэтгэгдлээ илэрхийлэх, ухуулга хийх, хүний эрх, сэтгүүлзүйн талаар ярилцлага өрнүүлэх, соёл урлагийн илэрхийлэл хийх, соён гэгээрүүлэх, шашны зан үйл хийх зэрэг орно.” 12 дэх хэсэгт өгүүлснээр “2 дахь хэсэг нь үзэл бодлоо илэрхийлэх бүхий л төрлийн илэрхийллийг хамгаална... түүний түүгээх бүхий л замуудыг... үүнд аудио-видео дүрс бичлэг болон цахим болон цахилгаан хэлбэрийн илэрхийллүүд байгтана” хэмээн хамгаалж өгсөн. Мөн [2004 оны Интернет орчинд Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, Тууштай байдлыг дэмжих хүрээнд ЕАБХАБ-ын Байнгын Зөвлөлийн Шийдвэр No. 633](#): “Оролцогч Улс нь Хүний эрхийн Түгээмэл Тунхагт дурьдсан байдгийн адилаар интернетийн орчинг нээлттэй байлгаж, үзэл бодлоо илэрхийлэх олон нийтийн талбар болгоход ажиллах ёстой...”

²¹ Торгууль шийтгэлийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 21-ээс 26 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр гэж байсныг 31-ээс 40 дахин болгож нэмэгдүүлсэн.

²² Ганц онцлох зүйл бол зардлын дээд хэмжээг ҮАГ болон СЕХ хамтран гаргах (Ерөнхийлөгчийн, УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн 43.3-р заалт, 49.3-р заалт, болон 48.3-р заалт тус бүр).

43. Хандивын хэмжээг иргэний хувьд 3 хүртэл сая төгрөг, хуулийн этгээдийн хувьд 15 хүртэл сая төгрөг байхаар хязгаарласанг хэвээр үлдээсэн байна. Сонгуулийн тухай хуульд заасан мөнгөн бус хандивыг талуудын тохиролцсон үнийн дүнгээр тооцно гэдэг заалтыг хассан нь талархууштай бөгөөд сонгуулийн хуулийн төсөлд мөнгөн бус хандивыг зах зээлийн дундаж үнээр тогтооно хэмээн зааж өгсөн байна. Энэ нэмэлт өөрчлөлт нь олон улсын сайн туршлагатай нийцэх бөгөөд сонгуулийн сурталчилгааны зардлын дээд хэмжээг мэхлэн төөрөгдүүлэх эрсдлийг арилгаж байгаа юм.

44. Сонгуулийн тухай хуулийн төслүүд нь бүгд сонгуулийн санхүүжилт болон зардлын явц дундын тайланг олон нийтэд нээлттэй мөн ҮАГ-т сонгуулийн өдрөөс 3 хоногийн өмнө хүргүүлэх заалтууд оруулсанг эерэгээр хүлээж авч байгаа бөгөөд энэ нь АИХЭГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлж сонгуулийн сурталчилгааны санхүүжилт болон зардлын тайлангийн шаардлагыг олон улсын хэм хэмжээ болон сайн туршлагатай нийцүүлсэн байна.²³ Гэсэн хэдий ч улс төрийн намууд ямар хэлбэрээр тухайн тайланг олон нийтэд ил болгох талаар тодорхой зааж өгөөгүй байна. *Энэ хүрээнд сонгуулийн зардлын тайланг нийтлэх заалтыг илүү тодорхой болгож өгвөл үр дүнтэй.*

45. Өөр нэг эерэг өөрчлөлт бол Авилгатай Тэмцэх Газар Ерөнхийлөгчийн сонгуулийн бүх нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг санал хураах өдрөөс 30 хоногийн өмнө өөрийн цахим хуудсанд байршуулах, УИХ-ын сонгуулийн бүх нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнө өөрийн цахим хуудсанд байршуулна гэсэн зохицуулалт юм.²⁴

46. Сонгуулийн санхүүжилт болон зардлын эцсийн тайланг хувийн аудитын байгууллагаар хянуулж ҮАГ-т улс төрийн нам бол сонгуулийн өдрөөс хойш 45 хоногийн дотор, харин бие дааж нэр дэвшигч бол 30 хоногийн дотор хүргүүлнэ. ҮАГ сонгуулийн сурталчилгааны дансанд аудит хийх болон санхүүгийн торгууль шийтгэл оногдуулах эрхгүй байна.²⁵ Сонгуулийн хуулийн төслийн хүрээнд ҮАГ-т нэмэлт эрх мэдэл олгоогүй, иймээс АИХЭГ-ын өмнөх холбогдох зөвлөмжүүд хүчинтэй хэвээр байна. *Тодруулбал, ҮАГ сонгуулийн хяналт болон аудитыг илүү үр дүнтэй хийх зохицуулалттай байх ёстой. Мөн ҮАГ торгууль шийтгэл оногдуулах эрхтэй байх ёстой.*

47. Сонгуулийн тухай хууль болон сонгуулийн тухай хуулийн төслийн хүрээнд сонгуулийн зардлын хязгаарыг зөрчих нь ямар ч торгууль шийтгэлгүйгээр зохицуулагдсан байна.

²³ [2004 оны Авилгын эсрэг НҮБ-ын Конвенцийн](#) 7(3) -р заалтад “Сонгогддог төрийн албан тушаалтны нэрийг дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болон холбогдох тохиолдолд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор оролцогч улс бүр [...] хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг авах асуудлыг мөн авч үзнэ.” [2011 Улстөрийн намын Зохицуулалтын тухай ЕАБХАБ/АИХЭГ болон Венецийн Комиссын хамтарсан Удирдамжаар](#) 194 дэх хэсэгт: “Ил тод байдал маш чухал учир нь сонгогчид талуудыг хариуцлагатай байлгахын тулд улс төрийн намуудад олгож буй санхүүгийн дэмжлэгийн талаар холбогдох мэдээлэл авсан байх эрхтэй.”

²⁴ 2017 онд, Авилгатай Тэмцэх Газар Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж буй 3 нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг санал авах өдрөөс 12 хоногийн өмнөөс олон нийтэд ил болгосон. Хэдий тийм боловч СТХ-д үүнийг нийтэд ил болгох хуулийн үүрэг хариуцлага байгаагүй.

²⁵ [2011 Улстөрийн намын Зохицуулалтын тухай ЕАБХАБ/АИХЭГ болон Венецийн Комиссын хамтарсан Удирдамжаар](#) 214 дэх хэсэгт: “Нам болон нэр дэвшигчдийн хүргүүлсэн санхүүгийн тайланд Төрийн хууль зохицуулах байгууллага дансыг хянаж, аудит хийх эрхийг эдэлнэ хэмээсэн. Энэхүү аудитыг гүйцэтгэх үйл явцыг холбогдох хуульд тодорхой зааж өгсөн байх ёстой.”

Сонгуулийн санхүүжилттай холбоотой зөрчилд үр дүнтэй, тууштай, хувь тэнцүү торгууль шийтгэл оногдуулах нь зүйтэй.

Ғ. СОНГУУЛИЙН ӨДӨР

48. Сонгуулийн хуулийн төсөлд санал өгөх, санал тоолох, дүн гаргах үйл явцын талаар дорвитой өөрчлөлт ороогүй байна. Ерөнхийлөгчийн сонгуулийн саналын хуудаст тухайн нам болон эвслийн Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн он, сар, өдрийг баримтлан бичнэ. Энэ нь Сонгуулийн тухай хуульд заасан шиг улс төрийн намын УИХ дахь эрх мэдэл, суудлын тоогоор бичигдэхгүй гэсэн үг. Мөн зөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал хурааж байхад цагдаагийн албан хаагч хамт байлцана гэж заасан байна.

49. Хуулийн төслийн бусад өөрчлөлтүүд санал авах байран дахь ажиглагчдад холбогдолтой байна. Нэр дэвшигчид гурав хүртэлх тооны ажиглагчийг томилж ажилуулах эрхтэй²⁶ (Сонгуулийн тухай хуулинд 4 гэж заасан) ба Төрийн бус байгууллага хоёр хүртэлх тооны ажиглагчийг (Сонгуулийн тухай хуулинд 1 гэж заасан) ажилуулах эрхтэй.

50. Санал тоолж дууссан даруй сонгуулийн дүнг шууд нийтлэх хуулийн шаардлага байхгүй байна. АИХЭГ-ын сонгуулийг ажиглах хорооны тайлангаар 2016 оны УИХ-ын сонгуулийн дүнг СЕХ сонгуулийн өдрөөс хэд хоногийн дараа нийтэлсэн ба гомдол шийдвэрлэх хугацаа дууссаны дараа сонгуулийн хэсэгчилсэн дүнг нийтэлсэн. Харин 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар дүнг нийтлээгүй. АИХЭГ-ын холбогдох зөвлөмжүүд хэрэгжилгүй үлдсэн хэвээр байна. *Сонгуулийн үйл явцад сонгогчдын итгэл үнэмшил, үнэн шударга байдлыг нэмэгдүүлэхийн тулд сонгуулийн хэсгийн түвшин дэх сонгуулийн хэсэгчилсэн дүнг нийтлэхэд хуулийн шаардлага нэвтрүүлэх нь зүйтэй.*

Г. СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

51. Сонгуулийн тухай хуулиар сонгуулийн маргааныг захиргааны болон шүүхийн тогтолцоогоор шийдвэрлэхээр зааж өгсөн. Сонгуулийн хороодын үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчигдсөн, сонгуулийн хорооны шийдвэрийг эс зөвшөөрөх буюу сонгуулийн хорооны эс үйлдэхүй зэрэг өргөдөл, гомдлын тухайн сонгуулийн хороонд гаргаж гаргасан шийдвэр нь дээд шатны хороонд давж заалдах боломжтой. СЕХ-ны шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар гаргах ба цаашлаад Дээд шүүхэд хандана.²⁷ Сонгуулийн дүнгийн талаарх маргааныг шийдвэрлэх тодорхой процесс байхгүй бөгөөд ерөнхий заалтын дагуу зохицуулагдаж байна. Гэсэн хэдий ч Монгол Улсын Үндсэн хуулийн цэц СЕХ-ноос гаргасан Ерөнхийлөгчийн болон УИХ-ын сонгуулийн дүн Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэхийг шийдэх эрхтэй.

52. Сонгуулийн тухай хуулинд заасны дагуу аливаа хэрэг, маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх хугацаа нь хэдий шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ердийн хугацаанаас бага байгаа хэдий ч АИХЭГ-ын сонгуулийг ажиглах хорооны ажигласнаар энэ хугацаа нь шалтгаангүйгээр урт байна. Мөн сонгуулийн цаг хугацаатай нийцэхгүй, хэрэг маргааныг үр

²⁶ Энэхүү заалтын үг өгүүлбэр нь намын/нэр дэвшигчийн төлөөлөгч болон сонгуулийн ажиглагч хоорондын ялгааг гаргаж өгөөгүй болно.

²⁷ Орон нутгийн сонгуулийн хувьд дээд шатны сонгуулийн хорооны шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрлэнэ.

дүнтэйгээр шийдвэрлэхэд саад болж байна. АИХЭГ-ын зүгээс маргаан шийдвэрлэх цаг хугацааг богиносгож, сонгуулийн үйл явцтай нийцүүлэх нь зүйтэй гэж зөвлөж байна.

53. Сонгуулийн тухай хуулийн төсөл нь Сонгуулийн тухай хуультай харьцуулбал цөөн заалт тусгасан байна. Маргаан шийдвэрлэхэд захиргааны хэсгийг авч үлдсэн ч нарийвчлал багатай байна;²⁸ сонгуулийн хорооны талаарх өргөдөл гомдлыг дээд шатны сонгуулийн хороонд гаргах бөгөөд түүнчлэн хариуг ажлын 3 хоногт багтаан бичгээр өгнө.

54. Ерөнхийлөгчийн болон УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төслүүдэд зааснаар “СЕХ-ны энэ хуульд заасан бүрэн эрхийн талаарх өргөдөл гомдлыг Үндсэн Хуулийн Цэцэд гаргана”.²⁹ Сонгуультай холбоотой маргааныг хянан шийдвэрлэхэд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Дээд шүүхийн эрх мэдлийг энэ хүрээнд хассаны шалтгаан нь тодорхойгүй байна. Үндсэн хуулийн цэцийн өмнө хүлээх энэхүү үйл явц нь СЕХ-ны шийдвэрийг Үндсэн Хуульд нийцүүлэх зорилготой³⁰ бөгөөд энэ нь сонгуулийн үйл явцын бүх үе шатанд хуулийн асуудлыг цаг хугацаанд багтааж, үр дүнтэй шийдвэрлэх хангалттай баталгаа болж өгөхгүй. Сонгуулийн тухай хуулийн төслийн заалтын үг өгүүлбэрийн хувьд зөрчлийг шийдвэрлэх арга механизм нь ЕАБХАБ-ын үүрэг хариуцлагатай нийцэж буй эсэхийг тогтоох боломжгүй.³¹ ***Бусад холбогдох хууль тогтоомжид заасан байж болзошгүй ч эрхээ хамгаалах үр дүнтэй сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоо бий болгох хэрэгтэй; хэрэг маргааны төрөл болон хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага зэргийг тодорхой зааж өгөх ба хянан шийдвэрлэх цаг хугацааг сонгуулийн үе шатуудтай нягт уялдуулсан байх ёстой.***

55. Сонгуулийн зөрчилтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Сонгуулийн тухай хуулийн төслүүд Зөрчлийн тухай хуулийг баримталсан байна. Орчуулсан хуулийн төслөөс харахад яг аль хуулийн заалтыг хэлж байгаа нь тодорхойгүй байна. Гурван хуулийн төсөлд байх нийтлэг нэг шинэ заалт бол “сонгуулийн холбогдолтой маргаан, өргөдөл гомдлыг шийдвэрлэх эрх бүхий байгууллага нь өөрийн онцлогоос хамаарч сонгуулийн жилдээ багтаан шийдвэрлэнэ хэмээн заажээ”. Энэхүү заалт нь эрүүгийн эсхүл захиргааны шинж чанартай зөрчлийн аль нь болох нь тодорхойгүй байх бөгөөд мөн өөр бусад төрлийн гомдол эсэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн энэхүү хуулийн төслийн заалтаар сонгуультай холбоотой маргааныг хянан шийдвэрлэхэд Сонгуулийн тухай хуультай харьцуулбал илүү урт хугацаа орох мэт харагдаж байна. Жишээ нь 6 дугаар сард явуулсан УИХ-ын сонгуультай холбоотой хэрэг маргааныг тухайн жилийнхээ 12-р сар хүртэл шийдвэрлэхийг зөвшөөрсөн гэж ойлгогдож байна. ***Шүүхээр хянан шийдвэрлүүлэх сонгуулийн холбогдолтой хэрэг маргааны хугацааг зааж өгсөн хуулийн төслийн заалтыг дахин тодорхой болгож, цаг хугацааны хувьд хуулийн шийдвэр хэрэгжих боломжтой байхаар тогтоож өгөх нь зүйтэй.***

²⁸ Жишээлбэл, сонгуулийн хорооны өмнө харицлага тооцох эсхүл өргөдөл гомдол гаргах, шүүхэд нэхэмжлэхтэй холбоотой заалтууд байхгүй байна.

²⁹ Орон нутгийн Засаг даргын сонгуульд дээд шатны сонгуулийн хорооны шийдвэрийг эхлээд Захиргааны хэргийн шүүх шийдвэрлэнэ.

³⁰ Үндсэн Хуулийн Цэцийн Хуулийн 8.2.6-р заалт (1992).

³¹ [1990 оны ЕАБХАБ-ын Копенгагений баримт бичгийн](#) 5.10-р зүйлд: “Үндсэн эрхийг хүндэтгэж, эрх зүйн бүрэн байдлыг хангах үүднээс хүн бүр захиргааны шийдвэрийн эсрэг залруулах үр дүнтэй арга хэрэгслүүдийн эрхтэй байх болно” гэж заажээ.

56. Зөвхөн орон нутгийн сонгуулийн тухай хуулийн төсөлд дараах заалт орсон байна: ‘Энэхүү хуульд заасан зөрчлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд маргаан үүсгэх эсэх шүүхийн шийдвэр эсхүл шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй (орчуулсан хуулийн төслөөс шууд иш татав)’. Энэхүү орчуулгаас ойлгоход сонгуулийн холбогдолтой маргааны (хэрэгсэхгүй болгох эсхүл торгууль ногдуулах) анхан шатны шүүхийн шийдвэр нь эцсийн байх бөгөөд дав закладах эрхгүй болно гэдэг утга агуулсан харагдаж байна. Эдгээр заалт нь хуулийн дагуу эрхээ хамгаалах боломжийг үгүй хийж шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай бусад хуулиудтай зөрчилдөх магадлалтай.